

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2018 оны 01 дүгээр
сарын 18-ний өдөр

Дугаар: 02

Улаанбаатар хот

Төрийн үйл ажиллагааг иргэн төвтэй болгож,
төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж
хэрэглээнд нэвтрүүлэх

Төрийн үйл ажиллагааг иргэн төвтэй болгож, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын яам, агентлагуудад Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. Засгийн газрын яам, агентлагууд төрийн цахим мэдээлэл солилцох "ХУР" системд техникийн нөхцөлийн дагуу холбогдох, төрийн үйлчилгээний платформыг ашиглах.

2. Засгийн газрын яам, агентлагууд цахим хэлбэрээр албан бичиг солилцох, иргэн, байгууллагуудад үзүүлж байгаа үйлчилгээндээ тоон гарын үсэг ашиглах ажлыг эхлүүлэн, хэвшүүлэх.

3. Цахим засгийн хөгжлийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллаж, үр дүнг зөвлөлд танилцуулахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргад үүрэг болгов.

4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа болон үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж бизнес процессын ре-инженеринг хийх ажлыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлж, үр дүнг энэ оны хоёр дугаар улиралд багтаан зөвлөлд танилцуулахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов:

- i. Тухайн салбарын төрөөс иргэн, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний жагсаалт;
- ii. Тухайн салбарын төрөөс иргэн, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт шилжих боломжтой, боломжгүйгээр ангилах;
- iii. Тухайн салбарын төрөөс иргэн, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээг хүргэж байгаа хууль, тогтоомжийн судалгаа хийх;
- iv. Тухайн салбарын төрөөс иргэн, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр өөрчлөгдөх шинэчилсэн ре-инженеренгийн зураглал гаргах;
- v. Цахим хэлбэрт шилжсэнээр өөрчлөлт оруулах шаардлагатай хууль, тогтоомжийг тодорхойлох.

- vi. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа болон үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж бизнес процессын ре-инженеринг хийхдээ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас арга зүйн чиглэл авах.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР